

Гүйцэтгэх захирлын 2024 оны 09 сарын 27 өдрийн  
НМ-А/24-036 тоот тушаалын Хавсралт №01

## “НОРМАУНТ” ХХК-ИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

Монгол Улсын хөгжлийн цаашдын чиг хандлагатай уялдуулсан орчин үеийн, олон улсын стандарт, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнд хамаарах хуулийн болон зохицуулалтын шаардлагуудад нийцэж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, экспортын чиг хандлагатай, харилцагчдын хэрэгцээ сэтгэл ханамжид тулгуурлан, аюулгүй ажиллагаа, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, сөрөг нөлөөллийг байж болох бага түвшинд хүргэж, өөрийн ажилчид болон сум орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулахгүй байх арга хэмжээг авч эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангасан, ил тод, хариуцлагатай уул уурхайн олборлох үйл ажиллагааг хөгжүүлэх бодлого баримтлан байнгын сайжруулалтыг хийнэ.

### “НОРМАУНТ” ХХК -ИЙН 2024 ОНЫ НМТ-НЫ ЗОРИЛТУУД

№	1. Чанарын менежментийн тогтолцооны зорилтууд	
1	Төлөвлөлт	Нүүрс олборлолтын хэмжээг захиалагч талын төлөвлөгөөнд үндэслэн уялдуулан оновчтой төлөвлөх
2	Хуулийн болон бусад шаардлагад нийцлийн хүрээнд	Үйл ажиллагаа, бүтээгдэхүүнд хамаарах хуулийн болон зохицуулалтын шаардлагуудад нийцэж ажиллана.
3		Түншлэгч, харилцагч, хэрэглэгчдийн шаардлагад нийцэж ажиллана.
4		Уул уурхайн экспортын гол нэрийн бүтээгдэхүүний ангиллыг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, үйл ажиллагааны бүхий л түвшинд мөрдлөг болгох
5		Үйл ажиллагааны бүтээмжийг өсгөн нэмэгдүүлэх зорилгоор олборлох салбарт шинжлэх ухаан, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх

6	<b>Чанар хангалт ба Хариуцлагатай уул уурхайн хүрээнд</b>	Уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах
7		Уул уурхайн салбарын үндэсний хүний нөөцийг бэлтгэхэд онцгой анхаарч, нарийн мэргэжлийн мэргэшсэн инженер, техникийн ажилтныг дотоод, гадаадын зохих шатны сургуульд бэлтгэж, чадавхжуулах
8		Уул уурхайн салбарын мэргэжлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын тогтолцоог бэхжүүлж, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох
9		Бүтээгдэхүүний боловсруулалтын бүх үе шатуудад дэвшилтэт технологи, итгэмжлэгдсэн лабораториудын хяналтаар бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулж ажиллана.
10		Олон нийт болон оролцогч талуудын харилцааны бүхий л түвшинд ил тод, нээлттэй, тэнцвэртэй, шуурхай байдлыг баримтална.
11	<b>Тогтвортой хөгжлийн хүрээнд</b>	Ханган нийлүүлэгчид, оролцогч талуудын чадамжийг хөгжүүлж, хамтын хөгжлийг чухалчилна.
12		Ажилтнууд болон олон нийтэд үйлчилгээ үзүүлж буй нийгмийн үйлчилгээг тогтвортой хадгалж, хүртээмж, чанарыг сайжруулан, хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг тэдний хүлээлтээс давуулан биелүүлэхийг чармайна
13	<b>Орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн эрх ашгийг хамгаалах</b>	Тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулагч, орон нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд орон нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх
14	<b>Тасралтгүй сайжруулалтын хүрээнд</b>	Ажилчдын мэдлэгийг байнга хөгжүүлж, тасралтгүй суралцагч байгууллага байна.
15		Компанийн хөгжлийн явц, цаг үеийн шаардлага, техник технологийн ололт амжилттай уялдуулан, байгууллагын мэдлэг, удирдлагын манлайлал, ажилтнуудын оролцоо, үр дүнтэй хөрөнгө оруулалт, үр нөлөөтэй дотоод аудитад

		үндэслэн чанарын менежментийн тогтолцооны тасралтгүй сайжруулалтыг хангана.
16		Компанийн хэмжээнд процесст суурилсан менежмент, бодит өгөгдөл, тоо статистикт суурьтай үнэлгээ мониторингийг хэвшүүлнэ.
17		Орчин үеийн техник технологийн хөгжил, мэдээллийн технологийн боломжуудыг ашиглан үйл ажиллагааны чанар бүтээмжийг дээшлүүлж дижитал шилжилтийг дэмжинэ.
18	<b>Гомдол</b>	Хэрэглэгчийн гомдлыг жил бүр үнэлж бууруулах
19	<b>Сэтгэл ханамж</b>	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин дээшлүүлэх / Захиалагч тал /
		Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин дээшлүүлэх /Дотоод буюу ажилтнууд/
		Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин дээшлүүлэх /Удирдлага, гэрээний түвшинд/
20	<b>Ажилтны чадамж</b>	Мэргэшлийг дээшлүүлэх
<b>2. Байгаль орчны зорилтууд</b>		
21	<b>Байгаль орчны багц хуулийн ницэл</b>	Байгаль орчны хууль тогтоомж, дүрэм, журам стандартуудын нийцлийг хангуулан ажиллах
21	<b>Эрчим хүч</b>	Эрчим хүчний хэрэглээг бодит тооцоолол хийж, байж болох хамгийн түвшинд барьж хэмнэлттэй үйл ажиллагаа явуулах
22	<b>Ус ашиглалт, Тоос</b>	Уурхайн технологийн замуудад шинэ дэвшилтэт технологи, бодис ашиглан тоосжилтыг бууруулах, усны хэрэглээг боломжит хэмжээд бууруулах
23	<b>Хог хаягдлыг бууруулах, Ногоон худалдан авалт</b>	Байгальд ээлтэй эко худалдан авалт хийхийг эрмэлзэж, ашиглалтаас үүдэлтэй хог хаягдлыг хамгийн бага байхаар тооцож, дахин ашиглах боломжийг эрэлхийлж ажиллах
24	<b>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө</b>	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгийн ажлууд 90%-аас доошгүй байх
<b>3. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын зорилтууд</b>		

25	<b>ХАБЭА-н оролцоо ба манлайлал</b>	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэн компани дах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулан, хэрэгжилтийг хангуулан ажиллах
26	<b>Эрүүл, аюулгүй ажлын байр</b>	Үйл ажиллагаанаас үүдэлтэй үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, байгаль орчинд үзүүлэх хүчин зүйлийг нөлөөллөөс урьдчилан сэргийлж бүх л арга хэмжээг авч хэрэгжүүлэн. Ажилчдыг эрүүл аюулгүй ажлын байраар хангахад зорин ажиллах